



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

Г “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны Г
зуучлагч /брокер/-аас төвлөрүүлэх
зохицуулалтын үйлчилгээний хөлсний
хэмжээ”-г тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-аас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан худалдах болон худалдан авах гэрээний нийт дүнгийн 0.08 хувиар тогтоож, мөрдсүгэй.

2. Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, программд зохих өөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст төвлөрүүлж ажиллахыг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /ХААБ/-дын удирдлагад үүрэг даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000286